

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны  
12 дугаар сарын 27-ны өдрийн 10:00  
дугаар тушаалтын хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
 шинэчлэн боловсруулсан  
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023. 12. 27 10:00

#### Байгууллагын нэр:

Мөрдөн байцаах алба

#### Нэгжийн нэр:

Захиргааны удирдлагын хэлтэс

#### Албан тушаалын нэр:

Ахлах сэтгэл зүйч, полиграфич

#### Албан тушаалын ангилал, зэрэглэл:

TT-5

#### Ажлын цаг:

8 цаг

#### Ажлын байрны албан ёсны байршил:

Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,  
Самбуугийн гудамж-18

#### Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

#### Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд уртасгасан цагаар болон өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

#### Албан тушаалын зорилго:

Мөрдөн байцаах албаны алба хаагч, ажилтнуудын сэтгэл зүйн таатай орчинг бүрдүүлж сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд туслах, удирдлагыг сэтгэл зүйн мэдээллээр хангаж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд мэргэжлийн үйлчилгээ тусlamжийг үзүүлэх мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын мэдүүлэг бодит байдалтай нийцэж байгаа эсэхийг полиграфийн төхөөрөмжийн тусlamжтайгаар судлах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх.

1. Мөрдөн байцаах албаны алба хаагч, ажилтнуудад сэтгэл зүйн мэдлэг, мэдээллээр хангаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээг хургэх.
2. Байгууллагын алба хаагчдын талаар сэтгэл зүйн судалгаа оношилгоо хийж, удирдлагыг мэдээллээр хангаж, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх.

- 3.Мөрдөн байцаах албанда ажиллахаар хүсэлт гаргасан иргэн, цагдаагийн алба хаагч болон албан тушаал хөрвөж ажиллах алба хаагчидтай сэтгэл зүйн ярилцлага хийж, тодорхойлолт, санал гаргаж удирдлагад танилцуулах.
- 4.Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдын шалтгаан нөхцөлийг судалж удирдлагад танилцуулж санал оруулах.
- 5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын мэдүүлэг бодит байдалтай нийцэж байгаа эсэхийг полиграфийн төхөөрөмжийн тусlamжтайгаар судлах, тэдэнд болон тэдний ар гэрт сэтгэл зүйн зөвлөгөө өгөх.
- 6.Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах -Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1.Цагдаагийн алба хаагчдыг сэтгэл зүйн мэдээллээр хангаж, сэтгэл зүйн зөвлөгөө, заслыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны холбогдох журамд заасны дагуу хийх;</p> <p>1.2.Шаардлагатай тохиолдолд гэмт хэргийн хохирогч (насанд хүрсэн болон насанд хүрээгүй) болон гэмт хэрэг үйлдээд мөрдөн шалгагдаж байхдаа саад учруулж байгаа сэжигтэнтэй ажиллахад мэргэжлийн зөвлөгөө, тусlamжийг үзүүлэх;</p> <p>1.3.Байгалийн гамшиг, осол гэмтэл, нийтийг хамарсан эмх замbaraагүй байдлын үед мэргэжлийн туслалцааг зохион байгуулах;</p> <p>1.4.Онц ноцтой гэмт хэргийн дуудлагад ажилласан албан хаагчдад сэтгэлийн хямрал, траум, цочролоос гарахад нь сэтгэл зүйн зөвлөгөө, засал хийж, тайвшруулах мэргэжлийн тусlamжийг цаг алдалгүй хүргэх;</p>	Алба хаагчдын сэтгэл зүйн дарамт, стресс буурч, сэтгэл санааны байдал тогтвржсоноор сэтгэл зүйн эрүүл таатай уур амьсгалыг бий болж, ажиллах урам зориг нэмэгдэнэ.	Г Г Г Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1.Сэтгэл зүйн судалгаа оношилгоо хийх, удирдлагыг сэтгэл зүйн мэдээллээр хангаж, мэргэжлийн туслалцааг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны холбогдох журамд заасны дагуу үзүүлэх;</p> <p>2.2.Цагдаагийн алба хаагч, ажилтны сэтгэцийн байдалд тандалт судалгаа хийх ажлыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код-938.3.5-д заасны дагуу</p>	Удирдах ажилтан нь байгууллагын сэтгэл зүйн уур амьсгал, алба хаагчдын сэтгэл зүйн онцлог байдлыг танин мэдсэнээр алба хаагчдынхаа тогтвортой, сэтгэл ханамжтай	Г Г

	мэргэжлийн байгууллага, эмчтэй хамтран зохион байгуулах. 2.3 Хэлтсийн даргын баталсан хуваарь, үүргийн дагуу даалгасан ажлыг зохион байгуулж, дүнг танилцуулах;	ажиллах нөхцлийг бурдүүлж, удирдахуйн ур чадварын түвшин нэмэгдэнэ.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Цагдаагийн байгууллагад ажилд орох, суралцах хүсэлт гаргасан иргэнийг судлах, мэргэшлийн шалгалтад сэтгэл зүйн ярилцлага хийх, сэтгэл зүйн байдлыг тодорхойлох ажлыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны холбогдох журамд заасны дагуу хийж, үнэлэлт дүгнэлтийг танилцуулах; 3.2.Цагдаагийн байгууллагад шинээр ажилд орсон алба хаагч, ажилтнуудыг богино хугацаанд дасан зохицуулахад Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны холбогдох журамд заасны дагуу сэтгэл зүйн дэмжлэг туслалцааг үзүүлэх.	Цагдаагийн байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцсэн "Зөв" тогтвортай суурьшилтай хүний нөөцийг сонгон авч ажиллуулсанаар тогтвортой ажиллах байдал дээшилж, албаны үйл ажиллагааны үр дүн, нэр хүнд нийгэмд өсөн нэмэгдэнэ.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1.Цагдаагийн алба хаагчдыг сэтгэл зүйн мэдээллээр хангаж, сэтгэл зүйн зөвлөгөө, заслыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны холбогдох журамд заасны дагуу хийх.	Сахилгын зэрчлийн тоо буурч ажиллах урам зориг нэмэгдэнэ.	Г
5 дугаар зорилтын хүрээнд	5.1.Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд полиграфын төхөөрөмж ашиглан асуулга явуулахад Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 302-д заасны дагуу хэрэгжүүлж ажиллах	Гэмт хэргийн холбогдогч нарын мэдүүлгийн үнэн худлыг тодруулна.	Г
Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	6.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх; 6.2.Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн, "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх; 6.3.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.	-	Г Г Г

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
-----------	---

<b>Мэргэжил</b>	Сэтгэл судлал /0313/		
<b>Мэргэшил</b>	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
<b>Туршлага</b>	Цагдаагийн байгууллагад 6-аас доошгүй жил, үүнээс нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын офицер албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх		
<b>Үр чадвар</b>	Дүн шинжилгээ хийх	-Мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; -Нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; -Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх; -Судалгааны арга зүйн мэдлэгтэй;	
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; -Асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох; -Удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах.	
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.	
	Бусад	-Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, уг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх. -Компьютерийн Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point программуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх. -Нууц хадгалах.	

#### IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

**Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:**

Захиргааны удирдлагын хэлтсийн дарга

<b>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</b>	<b>Бусад харилцах субъект:</b> <b>Шууд харилцах байгууллага:</b> -Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан; <b>Шууд бус харилцах байгууллага:</b> -Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.
--	---

#### V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

<b>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</b>	<b>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</b>
---	--

Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

Т.ГАНЗОРИГ

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Байгууллагын нэр: .....  
Шийдвэрийн огноо: .....  
Дугаар:.....

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-өдөр  
Дугаар: 101

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.СҮХБОЛД

2023 оны 27 дугаар сарын 27-ны өдөр

**ТАНИЛЦСАН:**

Албан тушаалтан: .....

20... оны .... дугаар сарын ....-ны өдөр